

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН
СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ БОЛОН ШАЛГАЛТ АВАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй /цаашид “ХАБЭА” гэнэ/-н сургалтын төрөл, агуулга, суралцагчид болон сургалт явуулах байгууллага, багшид тавигдах шаардлага, сургалтын байгууллагыг бүртгэх, гэрчилгээ олгох, сунгах, цуцлах, хяналт тавих болон шалгалт зохион байгуулах, суралцагчдад сертификат олгохтой холбогдох харилцааг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон энэхүү журмаар зохицуулна.

1.2 ХАБЭА-н сургалтын байгууллагын үйл ажиллагаанд хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллага /мэргэжлээс шалтгаалсан өвчин, хөдөлмөрийн нөхцөл хариуцсан байгууллага/, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллага мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллана.

1.3 Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчдад ХАБЭА-н сургалтыг жилд нэгээс доошгүй удаа явуулна. Тухайн сургалтыг зохион байгуулах ХАБЭА-н сургалтын байгууллагын сонгон шалгаруулалтыг Нийгмийн даатгалын ерөнхий газар, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллага хамтран зохион байгуулж, аймаг, дүүргийн хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

1.4 Ажил олгогч нь ажилтны сургалтыг ХАБЭА-н асуудал хариуцсан нэгж, ажилтан, зөвлөлөөр гүйцэтгүүлж хяналт тавих ба бүртгэлийн гэрчилгээ авсан байгууллагатай гэрээ байгуулан явуулж болно.

1.5 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллага нь ХАБЭА-н сургагч багшийн сургалт, тэдний ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтыг хариуцна.

1.6 Олон нийтийг хамарсан цар тахал, гамшиг осол зэрэг давагдашгүй хүчин зүйлсийн нөлөөний улмаас ХАБЭА-н сургалтыг цахим /зайн/ байдлаар зохион байгуулна.

1.7 ХАБЭА-н сургалтыг хууль тогтоомж, стандартын шаардлагын хэмжээнд зохион байгуулаагүй, гэрчилгээ аваагүй, гэрчилгээний хугацаа дууссан байгууллага явуулсан тохиолдолд Мэргэжлийн хяналтын байгууллагын холбогдох хяналтын чиглэлийн улсын байцаагч хууль тогтоомжид заасан эрхийнхээ дагуу арга хэмжээ авна.

1.8 Сургалтад суугаагүй иргэнд сертификат олгосон, сертификат хуурамчаар үйлдсэн, зассан, хосолсон сертификат олгосон, сургалтын материалыг хуурамчаар, хуурамч бичиг баримт ашигласан зэрэг зөрчлүүдийг гаргасан нь холбогдох хууль, хяналтын байгууллагаар нотлогдвол ХАБЭА-н сургалтын бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгож олон нийтэд мэдээлнэ.

1.9 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллага нь орон тооны бус ХАБЭА-н мэргэжлийн зөвлөлийг байгуулан, зөвлөлийн ажиллах дүрэм батлан ажиллана.

Хоёр. Сургалтын төрөл, агуулга

2.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт нь дараах төрөлтэй байна.

2.1.1 Ажил олгогч, удирдах ажилтны сургалт

2.1.2 Ажилтны сургалт;

2.1.3 ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны сургалт;

2.1.4 ХАБЭА-н сургагч багшийн сургалт;

2.1.5 Үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн үйлчлэл бүхий болон тэдгээртэй адилтгах эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байгаа иргэн, ажилтны сургалт;

2.1.6 ХАБЭА-н тусгай сургалт;

2.1.7 Олон нийтийн сургалт

2.1.8 ХАБ ба анхны тусламжийн сургалт

2.2 Ажил олгогч, удирдах ажилтны сургалт нь ХАБЭА-н талаарх ерөнхий мэдлэг, хөдөлмөрийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандарт шаардлага, байгууллагын түвшинд ХАБЭА-н арга хэмжээг төлөвлөн зохион байгуулах талаарх агуулгыг багтаахаас гадна нэгжийн удирдлага, инженер техникийн ажилтан болон аж ахуйн нэгж байгууллага дахь ХАБЭА-н зөвлөл, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх комиссын гишүүдийг чадавхжуулах сургалтын агуулгыг багтаасан байна.

2.3 Ажилтны сургалт нь аюулгүй ажиллах, ажлын байрны сөрөг хүчин зүйлсээс эрүүл мэндээ хамгаалахад зайлшгүй шаардлагатай ХАБЭА-н талаарх ерөнхий ойлголт, хөдөлмөрийн харилцаа болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, ажилтны ажлын байр, салбарын онцлогт тохирсон ХАБЭА-н талаарх агуулгыг багтаасан байна. Шинээр ажилд орж байгаа болон өөр ажлын байранд шилжиж байгаа иргэн, ажилтны сургалтын агуулга, хөтөлбөрийг ажил олгогч ажлын байрны онцлогтоо нийцүүлэн зохион байгуулна.

2.4 ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны сургалт нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, ХАБЭА-н үйл ажиллагааг зохион байгуулахад шаардлагатай онолын мэдлэг эзэмшүүлэх, практик дадал олж авахад чиглэсэн агуулгыг багтаасан байна. Бусад мэргэжил, сургалтын хөтөлбөртэй хослосон байдлаар зохион байгуулахыг хориглоно.

2.5 ХАБЭА-н сургагч багшийн сургалт нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндсэн асуудал, сурган, заах арга зүй, насанд хүрэгчийн сургалтын сэтгэл зүйн онцлог болон ХАБЭА-н асуудлаар сургалт явуулахад шаардлагатай онолын мэдлэг эзэмшүүлэх, практик дадал олгоход чиглэсэн агуулгыг багтаасан байна.

2.6 Үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн үйлчлэл бүхий болон тэдгээртэй адилтгах эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байгаа иргэн, ажилтны сургалт /цаашид “Эрсдэлтэй ажлын байрны сургалт” гэнэ/ нь тухайн ажил үүргийн онцлог шинж, учирч болзошгүй аюул осол, эрсдэл, түүнийг таньж илрүүлэх, урьдчилан сэргийлэх, хяналт тавих талаар зайлшгүй шаардлагатай онолын мэдлэг эзэмшүүлэх, практик дадал олж авахад чиглэсэн агуулгыг багтаасан байна. Даралтат сав, шугам хоолой, өргөх, зөөх тээвэрлэх механизмтай харьцаж ажиллах аюулгүй ажиллагааны сургалт нь холбогдох техник ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрэм, журмын агуулгыг багтаасан байна.

2.7 ХАБЭА-н тусгай сургалт нь тухайн ажил үүрэгтэй холбоотой учирч болзошгүй аюул осол, түүнийг таньж илрүүлэх, урьдчилан сэргийлэх, хяналт тавих талаар шаардлагатай онолын мэдлэг эзэмшүүлэх, практик дадал олж авахад чиглэсэн агуулгыг багтаасан байна.

2.8 Олон нийтийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт нь өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангах, эрүүл мэндийг хамгаалах, хүүхэд залуучуудыг гэмтэл, ослоос урьдчилан сэргийлэхэд зайлшгүй шаардлагатай ерөнхий мэдлэг олгох, ХАБЭА-н соёл төлөвшүүлэхэд чиглэсэн агуулгатай байна. ХАБЭА-н сургалтын байгууллага дээрх сургалтыг жилд нэгээс доошгүй удаа нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн байна.

2.9 Хөдөлмөрийн аюулгүй байдал ба анхны тусламжийн сургалт нь эрсдэлтэй ажлын байранд учирч болзошгүй аюул осол, түүнийг таньж илрүүлэх, урьдчилан сэргийлэх, хяналт тавих, осол гарсан тохиолдолд авах арга хэмжээ, анхны тусламж үзүүлэх, амь нас аврах талаарх шаардлагатай онолын мэдлэг эзэмшүүлэх, практик дадал олж авахад чиглэсэн агуулгыг багтаасан байна.

Гурав. Суралцагчдад тавигдах шаардлага

3.1 Үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн үйлчлэл бүхий болон тэдгээртэй адилтгах эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байгаа иргэн, ажилтан нь эрсдэлтэй ажлын байрны сургалтад 1 жил тутам хамрагдана. Даралтат сав, шугам хоолой, өргөх механизмтай харьцаж ажиллах аюулгүй ажиллагааны дүрмийн сургалтад хамрагдаж буй иргэн, ажилтан нь тухайн чиглэлээр дээд эсвэл мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшсэн байна.

3.2 Аж ахуйн нэгж, байгууллагын ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан нь ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны сургалтад хамрагдсан байна. ХАБЭА-н хөтөлбөрөөр их, дээд сургууль төгссөн ажилтан энэхүү сургалтад хамрагдахгүй байж болно. ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны сургалтад хамрагдах иргэд нь инженер, техникийн болон эрүүл ахуйн дипломын болон түүнээс дээш боловсролтой байна.

3.3 ХАБЭА-н сургагч багшийн сургалтад дараах шаардлагыг хангасан иргэн хамрагдана.

3.3.1 Дээд боловсролтой;

3.3.2 ХАБЭА-н чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай;

3.3.3 ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны сургалтад хамрагдсан эсхүл ХАБЭА-н хөтөлбөрөөр их, дээд сургууль төгссөн.

3.4 Хөдөлмөрийн аюулгүй байдал ба анхны тусламжийн сургалтад хамрагдах иргэнийг аж ахуйн нэгж байгууллагын захиалгаар сургана.

Дөрөв. Сургалт явуулах байгууллага, багшид тавигдах шаардлага

4.1 ХАБЭА-н сургалт явуулах байгууллага нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байна.

4.1.1 ХАБЭА-н асуудлаар мэргэшсэн, 3-аас доошгүй багш, арга зүйчтэй байх;

4.1.2 Энэхүү журмаар батлагдсан ХАБЭА-н сургалтын үлгэрчилсэн хөтөлбөрийг үндэслэж сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулсан байх; /сургалтын байгууллага салбар, ажил мэргэжлийн онцлогт тохируулан сургалтын хөтөлбөрт цаг агуулгыг нэмж болно./

4.1.3 1.6 дахь хэсэгт заасан нөхцөлд цахим сургалт зохион байгуулахдаа сургалт явуулах удирдамж аргачлал, сургалтын хөтөлбөр, хичээлийн хэрэглэгдэхүүн зэргийг ХАБЭА-н Мэргэжлийн зөвлөлөөр хянуулж батлуулна. /хасах/

4.1.4 Сургалтын анги танхимтай байх;

4.1.5 ХАБЭА-н сургалтын хөтөлбөрт заасан практик дадлыг эзэмшүүлэхэд шаардлагатай сургалтын техник, тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнтэй байх;

4.1.6 ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны, эрсдэлтэй ажлын байрны болон ХАБЭА-н тусгай сургалтын дадлага хичээлийг үйлдвэрлэлийн нөхцөл, ажлын байрны бодит орчинд хийлгэх боломжийг бүрдүүлсэн байх.

4.2 ХАБЭА-н сургалт явуулах багш дараах шаардлагыг хангасан байна.

4.2.1 ХАБЭА-н сургагч багш нь ХАБЭА-н чиглэлээр мэргэшсэн, ХАБЭА-н асуудлаар 5-аас доошгүй жил ажилласан ажлын туршлагатай байна. ХАБЭА-н сургагч багш нь багш мэргэжилтэй, багшлах эрхийн сургалтад хамрагдсан бол ХАБЭА-н сургагч багшийн шалгалт өгч тэнцсэн тохиолдолд сертификат олгоно.

4.2.2 ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны сургалтыг хөтөлбөрийн сэдэв, агуулгын дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал болон хөдөлмөрийн эрүүл ахуйн сургагч багш хичээл заана.

4.3 Хөдөлмөрийн аюулгүй байдлын багш нь дараах шаардлагыг хангасан байна.

- 4.3.1 ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны сургалтад хамрагдсан эсхүл ХАБЭА-н хөтөлбөрөөр их, дээд сургууль төгссөн;
- 4.3.2 Хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай;
- 4.3.3 ХАБЭА-н сургагч багшийн сургалтад хамрагдсан.
- 4.4 Хөдөлмөрийн эрүүл ахуйн багш нь дараах шаардлагыг хангасан байна.
 - 4.4.1 Хөдөлмөрийн эрүүл ахуйн хөтөлбөрөөр их, дээд сургууль төгссөн;
 - 4.4.2 Хөдөлмөрийн эрүүл ахуйн чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай;
 - 4.4.3 ХАБЭА-н сургагч багшийн сургалтад хамрагдсан.
- 4.5 Эрсдэлтэй ажлын байрны болон ХАБЭА-н тусгай сургалтын багш нь тухайн чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байна.
- 4.6 Даралтат сав, шугам хоолой, өргөх механизмтай харьцаж ажиллах аюулгүй ажиллагааны сургалтын холбогдох дүрмийн багш нь тухайн мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэрэгтэй байх.

Тав. Сургалтын байгууллагыг бүртгэх, гэрчилгээ олгох

5.1 ХАБЭА-н сургалт явуулахаар бүртгэлийн гэрчилгээ авах хүсэлтэй байгууллага нь дараах материалыг бүрдүүлж ирүүлнэ.

- 5.1.1 Бүртгэлийн гэрчилгээ авахыг хүссэн албан бичиг;
 - 5.1.2 Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар,
 - 5.1.3 Багш нарын анкет, иргэний үнэмлэх, боловсролын диплом, ХАБЭА-н сургагч багшийн сертификатын хуулбар;
 - 5.1.4 ХАБЭА-н сургалтын хөтөлбөр
 - 5.1.5 Сургалт явуулах байр, танхим, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангагдсан байдлыг гэрчлэх баримт, танилцуулга /гэрээ, гэрчилгээ, фото зураг г.м/;
 - 5.1.6 Аж ахуйн нэгж, байгууллага дээр дадлага сургалт зохион байгуулах бол энэ талаар харилцан тохиролцсон шийдвэр /гэрээ, албан бичиг, /
 - 5.1.7 ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны болон эрсдэлтэй ажлын байрны сургалтын сонгосон чиглэлээр хичээлийн иж бүрэн материал /лекц, конспект, дадлага болон семинарын хичээлийн удирдамж, шалгалтын материал/-тай байх.
- 5.2 ХАБЭА-н бүртгэлийн гэрчилгээ авах байгууллага нь албан хүсэлт, холбогдох материалаа Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллагад ирүүлнэ. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллага нь ажлын 20 хоногт багтаан сургалтын орчин нөхцөлд үзлэг үнэлгээ хийж шаардлага хангасан байгууллагад ажил олгогч, ажилтан, тусгай төрлөөр бүртгэлийн гэрчилгээ олгоно.
- 5.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллага нь ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны сургалт болон эрсдэлтэй ажлын байрны сургалтын сонгосон чиглэлээр бүртгэлийн гэрчилгээ авах байгууллагын материалыг шаардлага хангасан гэж үзвэл дүгнэлт, саналаа ХАБЭА-н үндэсний хорооны хурлаар хэлэлцүүлнэ. Даралтат сав, шугам хоолойтой болон өргөх зөөх тээвэрлэх механизмтай харьцаж ажиллах аюулгүй ажиллагааны сургалтын гэрчилгээ авах бол сургалтын хөтөлбөр, сургалтад ашиглах техник, тоног төхөөрөмжийн чадамжид мэргэжлийн хяналтын улсын байцаагч хяналт тавьж ажиллана.
- 5.4 ХАБЭА-н Үндэсний хорооны хурлын тэмдэглэлийг үндэслэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллага сургалтын байгууллагыг бүртгэж, гэрчилгээ олгоно.
- 5.5 Эрсдэлтэй ажлын байрны сургалт явуулах байгууллагыг бүртгэж, гэрчилгээ олгохдоо Даралтат сав, шугам хоолойтой харьцаж ажиллах ажилтны сургалтыг зуух, уур, усны даралтат сав болон газрын тос, хийн даралтат савны гэж төрлөөр нь, өргөх зөөх тээвэрлэх механизмтай харьцаж ажиллах аюулгүй ажиллагааны сургалтыг техникийн нэршлээр нь тус тус сургалтын чиглэлийг нарийвчлан заана.
- 5.6 ХАБЭА-н сургагч багшийн болон ур чадвар дээшлүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллага нь их дээд сургууль, мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж болно.
- 5.7 Хөдөлмөрийн аюулгүй байдал ба анхны тусламжийн сургалтыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллага нь мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулна.
- 5.8 ХАБЭА-н сургалтын байгууллагад олгох гэрчилгээний хүчинтэй хугацаа 3 хүртэл жил байна. Гэрчилгээнд олгосон огноо, хүчинтэй байх хугацаа, дуусах огноо, ХАБЭА-н сургалтын төрөл, эрсдэлтэй ажлын байрны сургалт болон ХАБЭА-н тусгай сургалтын чиглэл, бусад шаардлагатай мэдээллийг оруулна.
- 5.9 ХАБЭА-н сургалтын байгууллагад олгосон гэрчилгээний дугаар давхцахгүй байна.
- 5.10 Бүртгэлийн гэрчилгээ шинээр авах болон төрөл нэмүүлэх хүсэлт хүлээн авах хугацаа хоорондын зай 6 сар байна.

Зургаа. Бүртгэлийн гэрчилгээний хугацааг сунгах, цуцлах, хүчингүй болгох, хяналт тавих

6.1 ХАБЭА-н сургалтын бүртгэлийн гэрчилгээний хугацаа сунгуулах, төрөл нэмүүлэх, хасуулах хүсэлтээ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллагад энэхүү журмын 4 дэх хэсэгт заасан шаардлагыг хангаж ажилласан сургалтын үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээгээ холбогдох материалын хамт ажлын 30 хоногийн өмнө ирүүлж шийдвэрлүүлнэ.

6.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллага ажлын 10 хоногийн дотор судлан, сургалтын орчны үзлэг, үнэлгээ хийж, шаардлага хангасан байгууллагын бүртгэлийн гэрчилгээг 3 хүртэл жилийн хугацаагаар сунгах бөгөөд шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногт багтаан хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэнэ. Үзлэг үнэлгээний ажлын зардлыг тухайн сургалтын байгууллага бүрэн хариуцна.

6.3 Тайлант хугацаанд сургалт явуулаагүй төрлийг хасах, 1 жилээс дээш хугацаанд сургалтын үйл ажиллагаа явуулаагүй, тайлбар, тайлан мэдээ ирүүлээгүй тохиолдолд бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгож олон нийтэд мэдээлэх үүргийг Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллага хариуцна.

6.4 ХАБЭА-н сургалтын байгууллагуудын үйл ажиллагаанд 2 жил тутам хяналт үнэлгээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулж, дүгнэлт гаргана.

6.5 Хяналт үнэлгээний дүнг ХАБЭА-н үндэсний хороонд танилцуулж, хангалтгүй дүн үзүүлсэн эсхүл ажил олгогч, ажилтан, иргэдээс гомдол ирүүлсэн тохиолдолд сургалтын бүртгэлийн гэрчилгээг цуцлах, түдгэлзүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

6.6 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллага нь ажил олгогч, ажилтны болон ХАБЭА-н тусгай сургалт, олон нийтийн сургалтын байгууллагын бүртгэлийн гэрчилгээг цуцлах, түдгэлзүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

6.7 ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны буруутай үйлдлээс үйлдвэрлэлийн осол, хурц хорлого гарсан нь тогтоогдсон бол тухайн ажилтныг сургасан ХАБЭА-н сургалтын байгууллагын ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны сургалтын төрлийг цуцлах тухай асуудлыг ХАБЭА-н Үндэсний хорооны хуралд оруулж шийдвэрлүүлнэ.

6.8 ХАБЭА-н сургалтын байгууллага нь журмын 6.3, 6.5, 6.7 дахь заалтад тусгагдсны дагуу бүртгэлийн гэрчилгээ нь хүчингүй болсон байгууллага, хуулийн этгээдийн дахин гэрчилгээ олгуулах, болон төрөл нэмүүлэх хүсэлтийг хүлээн авах хугацаа 2 жил байна.

Долоо. Шалгалт зохион байгуулах, сертификат олгох

7.1 Ажилтны сургалтад хамрагдсан ажилтнаас тухайн сургалт зохион байгуулсан байгууллага нь шалгалт авч сургалтад хамрагдсан ажилтны нэрсийн жагсаалт гарган, гарын үсэг зуруулж баталгаажуулна.

7.2 ХАБЭА-н сургагч багшийн шалгалтыг ХАБЭА-н Үндэсний хорооны тогтоолоор батлагдсан комисс зохион байгуулна.

7.3 Комиссын бүрэлдэхүүнд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллагын болон мэргэжлийн холбоод, их дээд сургуулийн багш, судлаачдыг оролцуулна. Комиссын гишүүн нь сурган заах аргазүйн болон ХАБЭА-н чиглэлээр 10 буюу түүнээс дээш жил ажилласан, ёс зүйн зөрчилд холбогдож байгаагүй, ашиг сонирхлын зөрчилгүй байна.

7.4 Комиссын гишүүдэд ажлын үр дүнгээс хамаарч урамшуулал олгоно.

7.5 ХАБЭА-н сургагч багшийн сургалт явуулах болон шалгалт зохион байгуулахтай холбоотой зардлыг сургалтад хамрагдах хүсэлт гаргасан суралцагчдаас гаргуулж болно.

7.6 Комиссын ажиллах журам, бүрэлдэхүүнийг ХАБЭА-н үндэсний хорооны тогтоолоор батлах бөгөөд жилд нэг удаа үйл ажиллагаагаа ХАБЭА-н үндэсний хороонд тайлагнана.

7.7. ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны сургалтад хамрагдсан суралцагчдын төгсөлтийн шалгалтад хөндлөнгийн үнэлгээ хийнэ. Хөндлөнгийн үнэлгээ хийх ажлыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллага удирдамжийн дагуу зохион байгуулна.

7.8 Хөндлөнгийн үнэлгээчин болон баталгаажуулалтын ажилтанг сургаж бэлтгэх, давтан сургах, үнэлэх үйл ажиллагааг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллагын захиалгаар тухайн чиглэлийн асуудал хариуцсан төрийн байгууллага зохион байгуулна.

7.9 Хөндлөнгийн үнэлгээний дүнд үндэслэн ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны сургалтад хамрагдсан төгсөгчдөд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллага сертификат олгож, төгсөгчдийн цахим мэдээллийн сан үүсгэнэ. Сертификатад хөтөлбөрийн сэдэв, цагийг бичсэн байна. ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны сургалтад хамрагдаж төгссөн иргэдэд сургалтын байгууллагаас давхар болон нэмэлт баримт олгохгүй.

7.10 ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтнаар ажиллаж буй иргэн 2 жил тутам хөндлөнгийн үнэлгээнд хамрагдаж тэнцсэн байх, тэнцээгүй тохиолдолд өмнөх сертификатыг хүчингүй болгож олон нийтэд мэдээлэх бөгөөд иргэн дахин сургалтад хамрагдана.

7.11 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллагын цахим мэдээллийн санд бүртгэлгүй иргэдийн нотлох баримтыг үндэслэн хөндлөнгийн үнэлгээнд хамруулж тэнцсэн тохиолдолд нэгдсэн мэдээллийн санд бүртгэж сертификатжуулна.

7.12 Ажил олгогчийн сургалт, ажилтны сургалт, эрсдэлтэй ажлын байрны болон ХАБЭА-н тусгай сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэн суралцагчдад сургалт зохион байгуулсан байгууллага нь сертификат олгож, мэдээллийн сан үүсгэнэ. Сертификатад хөтөлбөрийн сэдэв, цагийг бичсэн байна. Сертификатад төрийн захиргааны төв байгууллага болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллагын нэр, логог ашиглахгүй.

7.13 Даралтат сав шугам хоолойтой болон өргөх зөөх тээвэрлэх механизмтай харьцаж ажиллах аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулсан байгууллага нь холбогдох дүрмийн дагуу үнэмлэх олгож, мэдээллийн

сан үүсгэнэ. Үнэмлэхэд хөтөлбөрийн сэдэв, цагийг бичсэн байна. Шалгалтыг холбогдох дүрмийн дагуу зохион байгуулна

7.14 ХАБЭА-н сургалтад хамрагдсан суралцагчдаас авах шалгалтыг ярилцлага, дадлага, тест, бусад хэлбэрээр зохион байгуулна. Шалгалтанд тэнцээгүй ажилтнаар тухайн ажлын байранд ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.

7.15 Сургалтад хамрагдсан боловч шалгалтад тэнцээгүй, хангалтгүй дүн үзүүлсэн тохиолдолд дахин шалгалт авч болно.

Найм. Сургалтын санхүүжилт

8.1 Ажил олгогч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулахад шаардлагатай байр, техник, хэрэгсэл, сургалтын материал бусад шаардлагатай зардлыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5.1-д заасны дагуу санхүүжүүлнэ.

8.2 Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчдад хийх ХАБЭА-н сургалтын зардлыг Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тухайн жилийн төсөвт тусгаж шийдвэрлэнэ.

Ес. Сургалтын тайлан, статистик мэдээ

9.1 ХАБЭА-н сургалт явуулахаар бүртгүүлж, гэрчилгээ авсан байгууллага нь сургалтын төрөл, сургалтанд хамрагдсан ажилтан, сертификатын дугаар зэрэг мэдээллийг улирал бүр гаргаж дараа сарын 5-ны дотор цахимаар, жилийн эцсийн мэдээг цахимаар болон цаасаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллагад ирүүлнэ.

9.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллага нь ХАБЭА-н сургалтын байгууллагуудын тайлан мэдээг улирал бүр нэгтгэн гаргаж, дараа сарын 21-ний дотор хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахимаар хүргүүлнэ.

оОо

НЭМЭЛТ САНАЛУУД:

1. Сургагч багш болон хөндлөнгийн үнэлгээчид, хөтөлбөрийг атестатчилдаг байх Энэ асуудлыг ХНХЯ дээр байгуулагдах ажлын хэсэгт шилжүүлэхээр ажлын хэсэг протокольдоо тэмдэглэсэн.
2. ЭӨАБ-ны сургалтын төрөлд доорх төрлүүдийг нэмэх
 - a. Цахилгааны аюулгүй ажиллагаа
 - b. Хуримтлагдсан энергитэй харьцаж ажиллах аюулгүй ажиллагаа
 - c. Өндөр хэмийн ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагаа
3. Тусгай сургалтын төрөлд доорх төрлүүдийг нэмэх
 - a. ААНБ дахь ҮОХХ-ыг судлан бүртгэх комиссын гишүүдийг чадавхжуулах
 - b. ААНБ дахь ХАБЭА-н зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах
 - c. ААНБ дахь Эрсдлийн үнэлгээ хийх багийн гишүүдийг чадавхжуулах
 - d. Тусгаарлалт /цоож пайз/ /хасах/ ажлын байрны төрөл тус бүр дээр заагдах тул тусгайлан орох шаардлагагүй
 - e. Агаарын найрлага хэмжигчийн сургалт /хасах/ ажлын байрны төрөл тус бүр дээр заагдах тул тусгайлан орох шаардлагагүй

Энэ саналыг тусгах хувилбарыг оруулсан боловч ажлын хэсэг хуульд зэрэглэлийн асуудал тусгаагүй тул хууль давсан журам болох үндэслэлээр татгалзсан болно

4. 7.10 дахь заалт дээр бас ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтныг дотор нь зэрэглэлтэй болгох
 - a. ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан
 - b. ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэшсэн ажилтан
 - c. ХАБЭА-н асуудал хариуцсан зөвлөх ажилтан
5. 4- дэх саналтай холбоотойгоор ийм заалт оруулж болох юм. 7.12 “ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны ур чадварт зэрэглэл тогтоох дүрэм”-ийг ХАБЭА-н мэргэжлийн зөвлөл боловсруулж ХАБЭА-н Үндэсний хороогоор батлуулан хэрэгжүүлнэ. Ингэж оруулбал одоо 7.10-д байгаа ногоон заалт хамааралгүй болоод хасагдана гэсэн үг.